



## ЦЭНГЭЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймаг дахь  
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор  
М.Хуанган  
Утас:70422954  
Цахим хаяг:

Аудитын менежер:  
Х.Женисбек  
Утас: 70422930  
Цахим хаяг:

Аудитор: Д.Назгүл  
Утас:99427301  
Цахим хаяг:

**Хаяг:** Баян-Өлгий аймаг дахь  
Төрийн аудитын газар

**Байршил:** Өлгий сум, 5-р баг,  
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р  
давхар

**Цахим хуудас:** [www.bayan-ulgii.gov.mn](http://www.bayan-ulgii.gov.mn)

2018 оны 3 дугаар сар

### Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээ тохирох загварын талаарх дүгнэлт

## Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 14-нээс 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Д.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 03-р сарын 01-ний өдрийн №01/208 тоот албан бичгээр 3 дугаар сарын 05-нд ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 16-наас 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 26 -нд Цэнгэл сумын Засаг даргад гардуулна.

## **Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин**

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

“Хүний нөөц, газар, байгалийн баялаг, дээд бүтцийн давуу талдаа тулгуурласан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг газар тариалан, үйлдвэр, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцан бие биеэ нөхөх, зүй зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж, хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн сум болно” гэж сумын үйл ажиллагааны эрхэм зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу Цэнгэл сумын Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2017 оны төсвийг аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Цэнгэл сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй,  
хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим,  
түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 24-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан тэмдэглэл тодруулга, бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

#### **Тав. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

## Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

### **6.1. Орлого, татаас санхүүжилтийн талаар:**

#### **6.1.1 Улсын төсвийн санхүүжилт**

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 3519,0 сая төгрөгийн санхүүжилт, 3,8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

#### **6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт**

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 379,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 95,4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 22,7 сая төгрөг хүлээн авчээ.

#### **6.1.3 Үндсэн үйл ажиллагааны орлого**

Цэнгэл сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагаанаас 1,6 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 1,4 сая төгрөгийн орлого оруулж, 0.2 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

#### **6.1.4 Орон нутгийн татварын орлого**

Цэнгэл сумын ИТХ-аас сумын 2017 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 95.2 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 46.5 хувийг ХАОАТатвараас, 19.7 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 8,5 хувийг өмчийн татвараас, 25,3 хувийг бусад татвараас оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>Нийт орлогын дүн</b>	<b>95,2</b>	<b>95,4</b>	<b>-0,2</b>	<b>100,2%</b>
<b>Татварын орлого</b>	<b>95,2</b>	<b>95,4</b>	<b>-0,2</b>	<b>100,2%</b>
ХАОАТатвар	44,3	44,6	0,3	100,7%

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	18,7	15,5	3,2	82,9%
Өмчийн татвар	8,1	7,5	0,6	92,6%
Бусад татвар	24,1	27,8	-3,7	115,4%
<b>Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	0	0		

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 95,4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 0,2 сая төгрөгөөр буюу 0,2 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 100 хувийг татварын орлогоос орлогоос бүрдүүлжээ.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 0,3 сая төгрөгөөр буюу 0,7 хувиар, бусад татвар 3,7 сая төгрөгөөр буюу 15,4 хувиар давж биелсэн бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 3,2 сая төгрөгөөр буюу 17,1 хувиар, өмчийн татвар 0,6 сая төгрөгөөр буюу 7,4 хувиар тасарчээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 6,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 95,4 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 15,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумын төрийн сан дахь цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансаар нийтдээ 182.3 сая төгрөгийн орлогыг оруулж, аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна. Газрын төлбөрөөс .... сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **6.1.5 Бусад орлого**

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн санд 93,3 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 78,5 сая төгрөгийн, Байгаль орчныг хамгаалах санд 6,4 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн санд 4,5 сая төгрөгийн орлого оруулсан байна.

## **6.2. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:**

### **6.2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны

урсгал зардалд нийтдээ 4365,0 сая төгрөгийн төсөв батлагдсаны 3519,0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 459,1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 93,3 сая төгрөгийг ОНХСангаас, 274,8 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 18,7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тусгажээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 3518,3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 459,1 сая төгрөгийн, ОНХСангаас 94,3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 86,3 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 21,2 сая төгрөг нийтдээ 4164,3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Төсвийн зарлагын гүйцэтгэл 4101,2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч төлөвлөснөөс 263,8 сая төгрөгөөр бага зарлага гаргасан байна. Энэ нь Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төлөвлөсөн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.  
/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /мөнгөн дүнгээр/	Зөрүү /Хувиар/
<b>1</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>4365,0</b>	<b>4101,2</b>	<b>263,8</b>	<b>93,9%</b>
1.1	Урсгал зардал	4365,0	4101,2	127,3	93,9%
<b>2</b>	<b>Зардлыг сахуужуулах эх үүсвэр</b>	<b>4365,0</b>	<b>4179,3</b>	<b>188,8</b>	<b>95,7%</b>
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	3519,0	3518,3	0,7	99,9%
2.2	Орон нутгийн төсвөөс	459,1	459,1	-	100%
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	93,3	94,3	-1,0	101%
2.4	Үйл ажиллагааны орлогоос	274,8	86,3	188,5	31,4%
2.5	Урьд оны үлдэгдлээс	18,7	21,3	0,5	113,9%

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал: /сая төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сумын ИТХурал	57,7	57,6	0,1	99,8%
Сумын ЗДТГазар	447,7	447,6	0,1	99,9%
Бүрэн дунд сургууль	1821,5	1821,5		100,0%
Загастнуур сургууль	247,4	247,4		100,0%
Тыва сургууль	447,8	447,1	0,7	99,8%
Хүүхдийн 1-р цэцэрлэг	335,9	335,9		100,0%
Хүүхдийн 2-р цэцэрлэг	242,8	242,8		100%
Хүүхдийн 3-р цэцэрлэг	162,5	162,5		100%
Соёлын төв	75,6	75,4	0,2	99,7%
Руханият сургууль	186,9	186,9		100%
ОНХСан	65,3	66,3	-1,0	101,5%
СХСан	264,2	0,5	263,7	0,18%
БХСан	9,4	9,4		100%
<b>Бүгд</b>	<b>4365,0</b>	<b>4101,2</b>	<b>263,8</b>	<b>93,9%</b>



Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас ОНХСангийн төсвийг 1,0 сая төгрөгөөр хэтрүүлж, бусад байгууллагууд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4365,0	4101,2	263,8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2354,7	2354,7	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,6	258,6	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,2	384,9	0,3
Хангамж, бараа материалын зардал	42,6	42,5	0,1
Нормативт зардал	364,2	364,3	-0,1
Эд хогшил, урсгал засварын зардал	11,1	11,1	
Томилолт, зочны зардал	10,1	10,1	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54	53,7	0,3
Бараа үйлчилгээний бусад зардал	329,7	66,2	263,5
Бусад урсгал шилжүүлэг	489,4	488,5	0,9
Хөрөнгийн зардал	65,3	66,3	-1,0

### 6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 26,6 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 26,6 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

### 6.2.3 Сангуудын зарцуулалт

Цэнгэл сумын ОНХСан нь оны эхэнд 11,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 93,3 сая төгрөгийн санхүүжилт авч, 66,3 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд, 39,9 сая төгрөгийг Мал эмнэлгийн үйлчилгээний арга хэмжээний зардалд зарцуулж, оны эцэст үлдэгдэлгүй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 0,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 78,4 сая төгрөгийн орлогыг оруулж, тайлант онд зээл олгоогүй, бараа үйлчилгээний зардалд 0,4 сая төгрөг зарцуулж оны эцэст 78,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. СХСан нь жилийн эцэст 299,6 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан харилцах данс оны эхэнд 1,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 4,5 сая төгрөгийн орлого оруулж, 5,7 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 0,06 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

**6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга****6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал**

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>38,4</b>	<b>109,9</b>	<b>71,5</b>
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0	0	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	38,4	109,9	71,5
<b>3121</b>	<b>Төгрөг</b>			
31211	Төрийн сангийн харилцах	37,3	109,8	72,5
31213	Арилжааны банк дахь харилцах	1,2	0,06	-1,14

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 109,9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0,06 сая төгрөг нь арилжааны банкинд дахь, 109,8 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна.

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн 15,9 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын, 78,6 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 15,3 сая төгрөг нь БОХНС барьцааны дансны үлдэгдэл байна.

Арилжааны банкинд байгаа 0,06 сая төгрөг нь Эргэлийн эмийн сангийн /60282 төгрөг/ болон Хүүхдийн 2-р цэцэрлэгийн/2453,55 төгрөг/ дансны үлдэгдэл байна.

**6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал**

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>397,7</b>	<b>299,6</b>	<b>-98,1</b>
333	Татаас, санхүүжилтийн авлага	17,2		-17,2
333	Ажиллагсадтай хоблоотой авлага	0,6		-0,6
333	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,8		-1,8
335	Хувь хүмүүсээс авах авлага	378,2	299,6	-78,6

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 98,1 сая төгрөгөөр буурсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, болон ОНХСангийн татаас санхүүжилтийн авлага, болон бусад авлагуудыг барагдуулж ажилласан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

**6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал**

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>141,3</b>	<b>145,6</b>	<b>4,3</b>
351	Түүхий эд материал			
354	Хангамжийн материал	141,3	145,6	4,3

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 4,3 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 100 хувь нь хангамжийн материал байна. Тайлант онд нийтдээ 5,0 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

#### 6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>12094,5</b>	<b>12109,2</b>	<b>-14,7</b>
391	Газар			
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	12090,3	12105,0	-14,7
	<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	3291,7	3632,2	-340,5
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,2	4,2	-
	<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	3,8	4,1	-0,3

Үндсэн хөрөнгө оны эхнээс 14,7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 6,2 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 29,7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Төсөвт байгууллагууд нийтдээ 29,7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЗДТГазар нь 6,9 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 8,9 сая төгрөгийн, Тьва сургууль 4,8 сая төгрөгийн, Хүүхдийн 3-р цэцэрлэг 9,1 хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд 21,1 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 360,4 сая төгрөгийн элэгдэл тооцож, данснаас хассан үндсэн хөрөнгийн 19,6 сая төгрөгийг элэгдэлийг данснаас хасалт хийж, зөрүү хөрөнгө акталсаны гарзаар бүртгэсэн байна.

#### 6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>35,9</b>	<b>36,5</b>	<b>-0,6</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>35,9</b>	<b>36,5</b>	<b>-0,6</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>35,9</b>	<b>36,5</b>	<b>-0,6</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>			
41361	Байгууллагад төлөх өглөг	21,3	30,1	-8,8
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	14,6	6,4	8,2

Оны эцэст Соёлын төв 17,4 сая төгрөгийн, Ахлах сургууль 1,2 сая төгрөгийн, Загаст нуур сургууль 0,9 сая төгрөгийн, Тьва сургууль 13,2 сая төгрөгийн, Хүүхдийн 1-р цэцэрлэг 0,9 сая төгрөгийн, Хүүхдийн 2-р цэцэрлэг 0,7 сая төгрөгийн Хүүхдийн 3-р цэцэрлэг 0,6 сая төгрөгийн, ОНХСан 1,6 сая төгрөгийн нийтдээ 36,5 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

#### 6.3.6 Цэвэр хөрөнгө/өмчийн талаар

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн нийт дүн 8991,6 сая төгрөг буюу ЗГОКапитал

1835,4 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1197,3 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 5958,9 сая төгрөг байна. Тайлант онд -344,5 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 5958,9 сая төгрөг болж оны эхнээс буурсан байна.

### **Долоо. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 2017 онд хийсэн нийцлийн аудитаар Цэнгэл сумын төсөвт байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.1.4, 6.1.5, 6.3.8, 6.3.9 (10, 11, 12) , 6.1.2, 6.4.5 (6-11 сар), 4.1.1, 6.1.6, 6.4.5 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн ба 2017.12.21 №01/642 тоотын дагуу 3723,3 сая төгрөгний зөрчлийн биелэлтийг ирүүлсэн байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-Tsengel sumiin TTZ файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

### **Найм. Аудитын дүнгийн талаар**

#### **8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 24 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

#### **8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар**

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний Орон нутгийн орлогын бүртгэл, тайлагнал, санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл, төсөвт байгууллага, сангуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэх, тулган баталгаажуулах зэргээр ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

#### **8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар**

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг бус дараах алдаа, зөрчил илэрлээ.

1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тэмдэглэл тодруулгыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” батлах тухай зааварын дагуу бэлтгэж ирүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тусгаж, зөвлөмж болгов.

2. Сум хөгжүүлэх сан нь жилийн эцсийн байдлаар 299.6 сая төгрөгийн зээлийн авлагатай бөгөөд авлага нь хугацаа хэтэрсэн, авлагын үлдэгдэлд тайлант хугацааны хүүг тооцож, орлогоор бүртгэж аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлд тусгаж, дараа оны аудитаар алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөв.

#### **8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

#### **8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

#### **8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### **8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

#### **8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Цэнгэл сумын Сумын ИТХурал, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, Бүрэн дунд сургууль, Тыва сургууль, Хүүхдийн 1-р цэцэрлэг, Хүүхдийн 2-р цэцэрлэг, Хүүхдийн 3-р цэцэрлэг, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа.

Сумын Засаг даргын тамгын газар, Загаст нуур сургууль, ОНХСан, Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Аудитын үр дүнг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /мян. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Бүрэн дунд сургууль		1	1			
Тыва сургууль		1	1			
Хүүхдийн 1-р цэцэрлэг		1	1			
Хүүхдийн 2-р цэцэрлэг	97,4	1	1			
Хүүхдийн 3-р цэцэрлэг		1	1			
ТТЗ-ийн СНТ		1	1			
<b>Дүн</b>	<b>97.4</b>	<b>7</b>	<b>7</b>			

#### 8.10. Зөрчилгүй санал дүгнэлт

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас хавсаргав.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН  
Огноо:2018.03.25

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК  
Огноо:2018.03.25

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАЗГҮЛ  
Огноо:2018.03.25